

## СУРГУУЛИЙГ УДИРДАХАД АРДЧИЛАЛ ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

*Б. Даваасүрэн, профессор*

Сургуулийг удирдах ажилд ардчилал ил тод байдлыг нэвтрүүлэх нь цагийн шаардлагаар дэвшигдэж байгаа асуудал юм. Ерөнхий боловсролын сургуульд зөвлөл, хороо, комисс зэрэг өөрийгөө удирдах байгууллага байгуулснаар ардчилах ажлыг хийж байна гэж үзвэл өрөөсгөл талтай болно. Сургуулийн захиргаанаас удирдан зохион байгуулах үйл ажиллагааг ардчилах, сургалт хүмүүжлийн ажлыг ардчилах хэрэгтэй болно.

Сургуулийг удирдах явдлыг ардчилахын гол үндэс нь нэг хүний дур зоргоор авирлах, тухайн ганц хүний бодол санаагаар ажил явуулах, энэ үндсэн дээр олон түмнийг идэвхгүй, удирдлагын аясыг харсан байдалд хүргэхийг тэвчиж хамт олны идэвхи санаачлага, оргилсон хөдөлгөөний үндсэн дээр асуудлыг шийдвэрлэх, нэгэнт олноороо шийдсэн зүйлийг хэрэгжүүлэхийн төлөө хүн бүр бүтээлч санаачлагатай ажиллах уур амьсгалыг бий болгох явдал юм. Чухамхүү үүнтэй уялдан хувь хүн өөрийн үзэл бодлыг чөлөөтэй дэвшүүлэх олон эшт үзэл гарч ирж байгаа бөгөөд эдгээр олон үзэл санааны дундаас хамгийн оновчтой зөвийг сонгон олж, асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ.

Ийм учраас багш, дунд ахлах ангийн сурагч, эцэг эхийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй сургуулийн зөвлөл байгуулан ажиллуулж хамт олны амьдрал, үйл ажиллагаатай холбоотой гол зангилаа асуудлыг хэлэлцэж байх нь чухал юм.

Сургуулийг удирдах ажилд ардчиллыг нэвтрүүлэхийн тулд хүмүүсийн ажил үүргийн хуваарь тодорхой байх, хүн бүрийн ажил хариуцах чадвар өндөр байх, хяналт шалгалт тогтмол хийх шаардлагатай. Ардчиллыг гуйвуулж, эмх замбараагүй байх, дур зоргоор аашлах байдалд хүргэж болохгүй бөгөөд хамтын шийдвэр олны эрх ашигт хүн бүр захирагдах учиртай.

Ардчиллын нөхцөлд сургуулийг удирдахын тулд захирал, дэд захирлууд захиргааны аргыг аль болохоор багасгаж, эдийн засгийн арга, нийгэм, сэтгэл зүйн аргыг өргөнөөр хэрэглэж сурах хэрэгтэй юм. Сургуулийг эдийн засгийн аргаар удирдахын гол нөхцөл нь сургалт, хүмүүжлийн ажлын бодит үр дүнтэй уялдуулан багш нарт цалин хөлс олгох, урамшууллын хөшүүргийг зохистой ашиглах явдал мөн. Сургууль дээр

нөхөрсөг, илэн далангүй, зарчимч шаардлагатай харьцааг бий болгох, багш нар сурагчдыг хүнийх нь хувьд хүндэтгэн үзэх, хүн бүр хамт олны гишүүдийн төлөө дээд зэргээр санаа тавих уур амьсгалыг бий болгох нь ажлын амжилтанд сайнаар нөлөөлнө. Сургуулийн ажлын амжилт нь зөвхөн багш, сурагчдын хүчээр бүтэхгүй, эцэг эх өргөн олны зүгээс дэмжлэг туслалцаа авах шаардлагатай байгаа нь өнөөгийн нөхцөлд бүр ч тодорхой харагдаж байна Ийм ч учраас ажил хэргээ бусад хүмүүстэй нягт холбон явуулах чадварыг сургуулийн удирдлагууд эзэмших хэрэгтэй болж байна. Ардчилал нь ил тод байдалтай нягт холбоотой. Ийм учраас сургуулийг удирдах ажилд ил тод байдлыг нэвтрүүлэх шаардлагатай байна. Сургуульд ил тод байдлыг нэвтрүүлэхийн тулд сургалт, хүмүүжлийн талаар явуулж байгаа ажил, түүний үр дүнг ил тод мэдээлж, зохиож байгаа ажлын талаар эцэг эх, хөдөлмөрчид, сурагчдын дунд яригдаж байгаа зүйл зохих эзэндээ ил тод мэдэгддэг байх нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй. Сурагч хүн багшийнхаа ажлын дутагдлыг өөрт нь шууд хэлэх, эсвэл сургуулийн захиргаанд мэдэгдэх, үгүй бол сурагчдын байгууллагаар дамжуулан уламжлах явдал хэвийн үзэгдэл болж хэвшээгүй нөхцөлд ил тод байдал хэрэгжиж байна гэж үзэх үндэсгүй юм. Энэхүү ил тод байдал нь хүний дутагдлыг арилгах, ажлын амжилтыг ахиулах, хүнийг хайрлах энэрэнгүй шинжтэй байх ёстой бөгөөд үүнийг хов, жив, атаа, хорсол, байр суурь булаацалдах явдал хүний нэр төрийг гутаах үйлдэлтэй хутгаж огт болохгүй. Сургуулийн удирдлагын бүх шатанд ажлынхаа тайланг хамт олны өмнө тавьж хэлэлцүүлэх журмыг нэвтрүүлэх нь ил тод байдлыг хэрэгжүүлж байгаа нэг чухал хэлбэр юм. Ер нь сургуульд ардчилал ил тод байдлыг нэвтрүүлэх явдал нь энэрэнгүй зарчим дээр тулгуурласан, биесийг харилцан хүндэтгэсэн, хүний ахих дэвших, хөгжих нөхцөлийг бүрдүүлсэн байж л тодорхой үр дүнд хүрнэ.

Сургах, хүмүүжүүлэх үйл явцыг ардчилахын тулд хичээл, хүмүүжлийн ажил дээр сурагчид өөрийгөө удирдах эхлэлийг нэвтрүүлэх замаар тэднийг идэвхгүй сонсогч объектоос бүтээлч эрэлт хайлт хийх субъект болгон хувиргах

нөхцлийг бүрдүүлэхээр сурган хүмүүжүүлэх үйл явцыг зохион байгуулахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл багш захиргаадан хэлж тайлбарлаж, ойлгуулахыг голчлохгүйгээр сурагчдын өөрсдийнх нь бүтээлч үйл ажиллагааг зохион байгуулж, өөрсдөөр нь эрэлт хайлт хийлгэж мэдлэг эзэмшүүлэх. хүмүүжлийн дадал хэвшилтэй болгох тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй юм. Үүнтэй уялдан багшийн нэр хүнд дээр тулгуурласан захиргаадалтын сурган хүмүүжүүлэх ухааныг өөрчлөн хамтын сурган хүмүүжүүлэх ухаан болгох эрэлт хайлт хийгдэж байна.

Сурган хүмүүжүүлэх нэгдмэл үйл явцад ардчилал, энэрэнгүй ёсыг нэвтрүүлэхийн тулд сургах, хүмүүжүүлэх ажлын технологид зарчмын өөрчлөлт оруулах хэрэгтэй болж байна.

Сургах хүмүүжүүлэх ажлын зорилго, чиглэл, агуулга арга барил, хэлбэрийг бүхэлд нь эргэн харж багш, сурагчийн үйл ажиллагааны хоорондын уялдаа, холбоо хамааралд зохих өөрчлөлт оруулах шаардлагатай боллоо. Сурагчид өөрсдөө дур хүсэлдээ автагдан сурч хүмүүжих бие даан эрэлт хайлт хийх арга барил, хүсэл сонирхолтой болох, аж амьдралынхаа хэтийн чиг баримжааг эртнээс олж түүнд хэрэг болох мэдлэг, чадвар, хөгжил, хүмүүжлийг эзэмшихийн тулд шаргуу тэвчээртэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь сурган хүмүүжүүлэх үйл явцад ардчилал энэрэнгүй ёсыг нэвтрүүлэхийн чухал үндэс болно. Үүнтэй шууд холбоотойгоор сурагчдын өөрийн хүмүүжлийн асуудлыг өндөр хэмжээнд тавих, тэднийг өөрийгөө удирдах ёсонд хэвшүүлэх асуудал чухал болж байна. Сурагчид өөрийнхөө суралцах, бүтээх хөдөлмөрийг төлөвлөж чаддаг, үйл ажиллагаагаа зохион байгуулж чаддаг байх ёстой. Ингэж ажиллах нөхцөлийг сургууль дээр бүрдүүлбэл зохино. Жишээлбэл, хичээлийн кабинет гэхэд л сурагчид бие даан ажиллах бүхий л нөхцөл бүрдсэн, унших ном зохиол бэлэн, туршилт сорилт явуулах багаж хэрэгсэлтэй байх ёстой. Ер нь сургуулийг ардчилах, энэрэнгүй болгох, ил тод байдлыг хангах зорилтын үүднээс хичээлийн анги танхимын зохион байгуулалт, тавилга төхөөрөмж, тоноглол, сургуулийн засал, чимэглэлд ч зохих өөрчлөлт оруулах шаардлагатай болж байна.

Сурган хүмүүжүүлэх явцыг ардчилж, энэрэнгүй болгож байгаа тодорхой хэлбэр бол сурагчдын авьяас билэг, хүсэл сонирхолд нь тохируулан сургалт хүмүүжлийн ажлыг ялгавартай явуулах явдал мөн.

Хүүхдүүд ерөнхий боловсролын талаар заавал эзэмшсэн байвал зохих мэдлэгийн доод хэмжээ гэж байх бөгөөд түүнээс цааш сургуулийн дунд ба

ахлах ангид төрөлжүүлэн сурах нь илүү үр дүнтэй юм. Түүнчлэн урлаг биеийн тамирын авьяастай хүүхдийг бүр эртнээс төрөлжүүлэн сургаж, энэ явцад нь ерөнхий боловсрол эзэмшүүлж болох юм. Хүүхдийн дунд зохиох хүмүүжлийн олон талт ажил, хичээл сургуулиас гадуурх хүмүүжлийн ажлыг ч төрөлжсөн байдлаар явуулах нь ашигтай.

Сургалт хүмүүжлийн байгууллагыг олон хэлбэртэй байлгах, албан ёсны ба албан ёсны бус сургалтаар залуучуудад боловсрол олгох, хэдийд ямар шатны боловсрол эзэмшихийг хүүхэд өөрөө сонгох бололцоо олгох, сургалт хүмүүжлийн ажлын агуулгыг олон хувилбартай байлгах нь ардчиллын зарчимд нийцнэ. Сургуулийг ардчилах явцад хүүхдэд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх бололцоо олгож байх, тэдний нийгэм улс төрийн амьдралд идэвхитэй оролцуулах, багачуудын эрх үүргийн нэгдлийг хангаж байх шаардлагатай. Сурагчдад өөрийн хүчинд итгэх итгэл бий болгох, авьяас билгээ хөгжүүлэх бололцоо олгох, хөдөлмөрөөр амьдралаа тэтгэх итгэл, ухамсар төлөвшүүлэх, тэднийг бие даан ажиллах, суралцах, амьдрах бэлтгэлтэй болгох, аливаа ажлыг гүйцэтгэх арга барилтай болгох нь ардчиллын зорилтод нийцнэ. Сургуулийг удирдах, сурган хүмүүжүүлэх үйл явцыг зохион байгуулах ажлыг удирдахдаа ард түмний уламжлал, ёс заншилд тулгуурлах, хууль ёс, дэг журмыг дээд хэмжээгээр сахих, сахилга зохион байгуулалттай байх, өргөн олны сонирхлыг эрхэмлэн хүндэтгэхэд онцгой анхаарал тавих ёстой.

Хамт олны бүх гишүүдийн улс төрийн соёлыг өндөржүүлэх, ардчилал, ил тод байдлыг нэвтрүүлэх явдлыг өндөр соёлтой зөв хослоход сургуулийн удирдлага онцгой анхаарал тавивал зохино.

Ардчилал нь шаардлагыг сулруулах, сахилгыг бууруулахын нэр бус бөгөөд тэр тусмаа дээр дороос тавих хяналтыг хүчтэй болгох шаардлагатай. Сургуулийн захиргаанаас тавих хяналттай хослуулан өргөн олны зүгээс тэдний байгууллагын зүгээс тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Сургуулийг ардчиллын үндсэн дээр удирдахад саад болж байгаа зүйлүүд бол ухамсраар биш албадлагаар ажиллаж байсан хуучин хэвшил, сахилга зохион байгуулалтын сулрал, ардчиллыг далимдуулан хувийн ашиг завшааныг хичээж байгаа бэртэгчин үзэл, удирдах ажилтан, удирдуулах хүмүүс ардчиллын соёлд муу суралцаж байгаа явдал юм. Эдгээр дутагдлыг арилгахад удирдан зохион байгуулах үйл ажиллагааны голыг чиглүүлэх ёстой.

ЕБС-ийн удирдах ажилтан бэлтгэх дамжаанд уншсан лекцийн хураангуй эмхэтгэл. 1995